



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 33 болон 34 дахь долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 09-р сарын 11-нээс 09-р сарын 22-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас 2 долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 14 дэх дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас энэ оны 9-р сарын “Эдийн засгийн төлөв байдал” тайландаа дэлхийн эдийн засаг 2021 онд 5.7 хувиар, 2022 онд 4.5 хувиар өсөхөөр төсөөлжээ. Энэ нь өмнөх улирлын төсөөлөлтэй харьцуулахад 2021 онд 0.1 нэгж хувиар муудах, 2022 онд 0.1 нэгж хувиар сайжрах төсөөлөл юм. АНУ-ын эдийн засгийн өсөлт энэ онд 6.0 хувь буюу өмнөх улирлын төсөөллөөс 0.9 нэгж хувиар бууруулсан бол БНХАУ-ын эдийн засаг 8.5 хувиар өсөх төсөөллийг хэвээр хадгалжээ. Евро бүсийн эдийн засгийн эрчтэй сэргэлт, ирэх онд батлагдахаар хүлээгдэж буй АНУ төсвийн нэмэлт дэмжлэг болон өрхийн хадгаламж буурч, хэрэглээ нэмэгдэж

буй зэрэг нь хөгжингүй орнуудын өсөлтийг дэмжих төлөвтэй. Дэлхийн эдийн засаг цар тахлын өмнөх түвшинд дөхөж байгаа хэдий ч олон улс оронд /ялангуяа вакцинжуулалт бага түвшинд байгаа хөгжиж буй орнуудад/ үйлдвэрлэлийн зөрүү сөрөг, ажил эрхлэлт хэвийн түвшинд хүрээгүй байна. Мөн цар тахлын дельта хувилбарын тархалт вакцинжуулалт өндөр түвшинд байгаа орнуудын эдийн засагт харьцангуй бага сөрөг үр дагавартай байгаа хэдий ч дэлхийн эдийн засгийн өсөлтийн богино хугацааны төлөвийг бууруулж, дэлхий нийтийн нийлүүлэлтийн гинжин сүлжээ, тээврийн зардалд нэмэлт дарамт учруулж байна.

Хүснэгт 1. Дэлхийн санхүүгийн байгууллага, олон улсын агентлагуудын дэлхийн эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллүүд (хувиар)

	Байгууллагын нэрс	Төсөөлөл хийсэн огноо	2021 он			2022 он	
			Дэлхийн эдийн засгийн өсөлт	БНХАУ	АНУ	Евро бүс	Дэлхийн эдийн засгийн өсөлт
1	OECD	9/14/2021	5.7%	8.5%	6.0%	5.3%	4.5%
2	The EIU	9/14/2021	5.4%	8.0%	6.0%	4.6%	4.1%
3	Fitch	9/16/2021	6.0%	8.1%	6.2%	5.2%	
4	PWC	9/2021	6.1%	8.5%	6.5%	4.6%	4.3%

Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудсууд

- **The EIU байгууллагаас 9-р сарын 14-нд дэлхийн эдийн засгийн төсөөллөө шинэчлэн танилцуулж, дэлхийн эдийн засаг энэ онд 5.4 хувиар, ирэх онд 4.1 хувиар өсөхөөр төсөөллөө.** Энэ онд хөл хорио сулран, эрэлт нэмэгдэж, гадаад худалдаа сэргэж байна. Гэвч нийлүүлэлтийн сувгийн доголдол, олон улсын ачаа тээврийн гацаа, түгжрэл зэрэг нь гадаад худалдааны гол эрсдэл болж байна. Харин үйлчилгээний салбар алгуур сэргэж, 2023, 2024 оноос цар тахлын өмнөх түвшинд хүрэх төлөвтэй. Энэ онд үйлдвэрлэхээр төлөвлөсөн цар тахлын вакцины талаас илүү хувийг дэлхийн хүн амын 15 хувийг бүрдүүлдэг хөгжингүй улс орнууд урьдчилан захиалсан тул дэлхий даяар нийтийн дархлаа тогтоход илүү хугацаа шаардагдахаар байна. Цар тахлын тархалтыг давамгайлж буй дельта вирус нь вакцинд хамрагдаагүй иргэдийн дунд илүү богино хугацаанд хурдтай тархаж, 5-9 хүнд халдвар тараадаг нь батлагдаад байгаа тул нийтийн дархлаа тогтоход нийт хүн амын 60-70 хувь биш 90 хувь хүртэл хамрагдах шаардлагатай гэдэг судалгаа гараад байна. Түүнчлэн, одоогийн өндөр инфляц дунд хугацаанд хадгалагдах тохиолдолд Төв банкууд бодлогын төлөвөө хүлээлтээс эрт чангаруулж, эдийн засгийн өсөлтийг хязгаарлах эрсдэлтэй байна.
- **“Fitch Ratings”** улирал бүр нийтэлдэг “Глобал Эдийн Засгийн Төлөв” тайлангаа 9-р сарын 16-ны байдлаар шинэчилж, **дэлхийн эдийн засгийн өсөлтийг өмнөх төсөөллөөс 0.3 нэгж хувиар бууруулж, энэ онд 6.0 хувиар өсөх төсөөллийг танилцуулав.** Нийлүүлэлтийн хязгаарлалт эдийн засгийн сэргэлтийг хойш татаж, өсөлтийн төсөөллийг өмнөхөөс буурууллаа. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт

дотоод эрэлтийг муутгах төлөвтэй тул БНХАУ-ын өсөлтийн төсөөллийг энэ онд 8.4 хувиас 8.1 хувь болгож бууруулав. Мөн АНУ-д нийлүүлэлт хязгаарлагдмал хэвээр байгаа, дельта вирус тархалт өндөр байгаа тул өсөлтийн төсөөллийг энэ онд 6.8 хувиас 6.2 хувь болгов. Харин Евро бүсэд дархлаажуулалтын түвшин өндөр байгаа нь дельта вирус АНУ-тай харьцуулахад бага тархахад нөлөөлж, эдийн засгийн сэргэлт үргэлжлэх төлөвтэй тул бүсийн өсөлтийн төсөөллийг 5.0 хувиас 5.2 хувьд хүргэн нэмэгдүүлэв. Харин дельта вирус тархалт вакцинжуулалт багатай орнуудын эдийн засагт илүү хүндээр тусч байна. Түүнчлэн цар тахлын улмаас улс орнуудад хөдөлмөрийн нийлүүлэлт бүрэн сэргэж чадахгүй байна.

- **Өндөр давтамжтай үзүүлэлтүүд АНУ-ын эдийн засгийн сэргэлтийн хурд саарсныг илтгэж байна.** АНУ-д цар тахлын тархалт нэмэгдэж, Гүүгл хөдөлгөөнт байдлын индикатор нийтийн хөдөлгөөнт байдал удааширсныг зааж байна. Мөн агаарын замын түгжрэл 9-р сарын эхний 7 хоногт буурч, зочид буудлын захиалга 8-р сарын сүүл үетэй харьцуулахад 61 хувиар багасчээ. Автомашины борлуулалт өмнөх сараас 1.5 саяар буурч 8-р сард 13.1 сая болов. Харин хэрэглээ цар тахлын өмнөх түвшнээс хавьгүй дээгүүр хадгалагдаж байна. 7 хоногийн давтамжтай зарлагддаг хэрэглэгчийн сентиментийн Ipsos-Forbes индекс 6-р сард 62.4 хүрсэн бол 8-р сард хамгийн багадаа 54.8 хүртэл буурч, 9-р сарын эхний долоо хоногт 56.6 болж бага зэрэг өслөө. Энэ нь хэрэглэгчийн сентимент дельта вирус тархалтын дараа тогтворжих хандлагатайг илтгэж байна.

Эх сурвалж:

1. Bloomberg, [Keeping The Recovery On Track](#)



2. FitchRatings, [Global Economic Outlook – September 2021](#)
3. Financial Times, [Iron ore tumbles 20% in worst week since 2008 financial crisis](#)
4. S&P Global Rating, [Economic Research: U.S. Real-Time Data: The Economy Hits A Speed Bump](#)
5. PWC, [Economic projections](#)
6. Federal Reserve, [Federal Reserve press release](#)

2

БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Эдийн засгийн голлох индексүүдийн өөрчлөлт

- Цар тахлын шинэ хувилбарууд, үйлдвэрлэлийн бохирдол, технологи, боловсролын салбар, үл хөдлөх хөрөнгийн салбарт тавигдах эрх зүйн орчин чангарсан, эдийн засгийн сэргэлт удааширсантай холбоотойгоор Блүүмбергийн шинжээчид БНХАУ-ын 2021 оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 9.1 хувиас 8.9 хувь болгон буурууллаа. Улирлаар авч үзвэл 2021 оны 3-р улирлын төсөөллийг 6.8 хувиас бууруулж 6.5 хувь, 4-р улирлын төсөөллийг 5.6 хувиас бууруулж 5.5 хувь байхаар тус тус төсөөлж байна.
- БНХАУ-ын 8-р сарын ХҮИ-ээр хэмжигдэх инфляц жилийн 1 хувь, харин үйлдвэрлэлийн инфляц түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалан 9 хувьд хүрээд байна. Жижиглэн худалдаа 2.5 хувийн өсөлттэй байсан нь өнгөрсөн сарын 8.5 хувийн өсөлттэй харьцуулахад буурлаа. Ажилгүйдлийн түвшин 7-р сард 5.1 хувь байсан бол 8-р сард мөн 5.1 хувь буюу тогтвортой байна.
- БНХАУ-ын Ардын банкнаас¹ зээлийн өсөлтийг нэмэгдүүлэх, жижиг, дунд

бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор банкны заавал байлгах нөөцийн хэмжээг бууруулах, репо санхүүжилтийг олгох зэрэг төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч байгаа бөгөөд бодлогын хүүг ойрын хугацаанд нэмэгдүүлэхээргүй байгаа тухай шинжээчид мэдээллээ.

БНХАУ-ын үл хөдлөх салбар

- БНХАУ-ын үл хөдлөх салбарын 2 дахь том корпораци Evergrande² хөрвөх чадварын эрсдэлд ороод байна. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарт сүүлийн саруудад хөрөнгийн үнэ унаж байгаа нь тус группын эргэн төлөлт нь тулаад буй 310 тэрбум орчим ам.долларын өр төлбөр буюу БНХАУ-ын ДНБ-ний 2 хувьтай тэнцэхүйц өр төлбөрийг барагдуулахад хүнд болгож байна. Хэрвээ тус групп дампуурлаа зарлах тохиолдолд Lehman Brothers-ийн хэрэг буюу дэлхийн санхүүгийн хямралын дараа орохуйц хямрал нүүрлэхээр байгаа тухай шинжээчид анхааруулж байна.
- Энэ нь үл хөдлөх, барилгын салбарт сөргөөр нөлөөлж эхлээд байгаа бөгөөд БНХАУ-ын үл хөдлөх салбарын ААН-ийн хувьцааны ханш дэлхий даяар

¹ БНХАУ-ын Ардын банкнаас хоёр тулгуурт бодлогыг баримтлахаа зарласан бөгөөд үүнд мөнгөний бодлого болон макро зохистой бодлогыг хослуулан юанийн тогтвортой байдлыг хангаж, санхүүгийн системийн эрсдэлээс сэргийлэх зорилготой.

² Evergrande нь үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр БНХАУ-ын 230 хот дахь 1300 төслийг эзэмшдэг системийн ач холбогдолтой ААН юм. Дан ганц үл

хөдлөх хөрөнгийн салбар төдийгүй электрон машин, хүнсний үйлдвэрлэл болон бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг.



унаж, цаашдаа үл хөдлөхийн үнэ буурах хүлээлттэй байна.

- Үл хөдлөх хөрөнгийн салбар нь түүхий эдийн томоохон хэрэглэгч тул ган, төмрийн хүдэр, зэс болон бусад түүхий эдийн үнэ буурахад нөлөөлөх тухай шинжээчид анхаарууллаа. Түүнчлэн, БНХАУ-ын 2022 оны эдийн засгийн төлөвийг бууруулж, ирэх оны газрын тос, төмрийн хүдрийн хэрэглээг бууруулж болзошгүй гэж үзэж байна.
- БНХАУ-ын Ардын банкнаас Evergrande-ийн нөхцөл байдал дотоодын санхүүгийн системд нөлөөлөх эрсдэлээс сэргийлж богино хугацааны мөнгөний нийлүүлэлтийг өнгөрсөн 5 хоногийн турш 71 тэрбум ам.доллараар нэмэгдүүлээд байна. БНХАУ-ын үндэсний баяр нь олон хоногийн турш үргэлжлэх амралтын өдрүүдтэй төдийгүй 10-р сарын 1-нд тохиож байгаатай холбогдуулан баярын өмнөх өдрүүдэд үүсдэг бэлэн мөнгөний огцом эрэлтээс сэргийлэх зорилгоор уг арга хэмжээг авсан байна.
- Evergrande-ийн зүгээс олон нийтэд хандсан мэдэгдэл гаргаагүй боловч хугацаа нь тулаад байсан бондын хүүгийн төлбөрийг төлөхөө хөрөнгө оруулагчдад мэдэгдээд байв. Гэсэн хэдий ч 83.5 сая ам.доллар болон 47.5 сая ам.долларын хүүгийн төлбөрийг хугацаанд нь төлж чадаагүй бөгөөд шинжээчид БНХАУ-ын Засгийн газар зайлшгүй оролцох шаардлагатай байгаа тухай мэдээлсээр байна.

Төмрийн хүдэр

- БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7-р сард 8 хувиар, 8-р сард 12 хувиар тус тус буурсан бол оны эхний 8 сарын байдлаар 5 хувиар өсчээ. БНХАУ-ын Засгийн газраас энэ онд ган үйлдвэрлэлийн хэмжээг 1 тэрбум тонн буюу 2020 оны түвшинтэй ижил байх

зорилт тавиад байгаа тул оны үлдсэн саруудад ч гарцын хэмжээг танахаар байгааг шинжээчид анхааруулж байна.

- БНХАУ-ын Засгийн газраас авч буй дээрх шийдвэр нь төмрийн хүдрийн үнэ буурахад голлон нөлөөлсөн бөгөөд төмрийн хүдэр үйлдвэрлэгчид хоёрдогч зах дээр бүтээгдэхүүнээ хямдралтай үнээр зарахад хүргэв. Төмрийн хүдрийн эрэлтийг сулруулж буй хоёр дахь томоохон хүчин зүйл нь БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар бөгөөд энэ оны 4-р улирлаас эхлэн 2022 оны туршид барилга, бүтээн байгуулалт удаашрах төлөвтэй байна.

Ган, коксжих нүүрсний импорт, эрэлт, нийлүүлэлт

- БНХАУ-ын 8-р сарын нүүрсний импорт 28 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 35.8 хувиар өссөн нь 2020 оны 12-р сараас хойших огцом өсөлт боллоо.
- БНХАУ-ын дотоодын коксжих нүүрсний үнэ 9-р сарын 10-ны өдрийн байдлаар Хэбэй Тангшанд нэг тонн нь 630 орчим ам.доллар буюу өмнөх долоо хоногоос 31 орчим ам.доллараар нэмэгдэв.
- БНХАУ-ын нүүрсний үйлдвэрүүдэд тавих хяналт шалгалт чангарч, оны эхний 8 сарын байдлаар нийт 905 уурхайд шалгалт орж, 204 уурхайн үйлдвэрлэлийн зөвшөөрлийг цуцалсан байна.
- Түүнчлэн, коксжих нүүрсний үйлдвэрлэлд тавигдаж буй хяналт шалгалтууд нь нүүрсний нийлүүлэлтэд хүндрэл учруулж цаашдаа ч үнэ өсөх хүлээлттэй байна. Тухайлбал, хяналт шалгалттай холбоотойгоор Шангдоны нүүрсний үйлдвэрийн гарцын хэмжээ 50 хувиар буурав. Харин Шиаяу, Шанси дахь нүүрсний уурхайд осол гарсантай холбогдуулан уурхайн аюулгүй байдлыг хангах хүрээнд гарцын хэмжээг 50 хувиар бууруулах



шийдвэрийг эрх баригчид гаргаад байна.

- Байгалийн гамшигт үзэгдлээс шалтгаалан Индонезийн нүүрсний уурхайн нийлүүлэлтэд тасалдал үүссэн нь БНХАУ-ын импортод тодорхой хэмжээгээр нөлөөллөө. Индонезийн эрчим хүчний 1 тонн нүүрсний үнэ 153 ам.долларт хүрч, өмнөх сараас 14.5 хувиар өсөв.
- Оросын төмөр замын тээврээр экспортлох нүүрсний хэмжээ энэ оны эхний 8 сарын байдлаар 246 сая тоннд хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар өссөн үзүүлэлт болов.

Монголын нүүрсний нийлүүлэлт

- БНХАУ-аас импортлох Монголын нүүрсний нийлүүлэлт тасалдсан хэвээр байгаа бөгөөд 9-р сарын 10-ны өдрийн байдлаар 1 тонн коксжих нүүрсний үнэ 67 ам.доллараар нэмэгдэж 336 ам.доллар хүрээд байна. Цар тахлын хязгаарлалт үргэлжилж, долоо

хоногийн дунджаар өдөрт 74 ачааны машин хилээр нүүрс экспортолж байна. Гашуунсухайт боомт дээрх нүүрсний үнэ 465 ам.доллар/тонн, Сэхэ боомт дээрх нүүрсний үнэ 324 ам.доллар/тонн орчимд хэлбэлзэж байна.

- Монгол Улс 8-р сард БНХАУ руу 1 сая орчим тонн нүүрс экспортлосон нь өмнөх оны мөн үеэс 73.8 хувиар бага байв. Энэ оны эхний 8 сарын байдлаар 179 сая ам.долларын 10.43 сая тонн нүүрс экспортлоод байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 28.4 хувиар буурсан үзүүлэлт юм.

Эх сурвалж:

1. [China: What is Evergrande and is it too big to fail?, BBC](#)
2. [China's Evergrande issue rattles commodity market; experts weigh in, CNBC](#)
3. [Commodities: the Chinese real estate exposure, Financial Times](#)
4. [Some Evergrande offshore bondholders don't expect payment by Thursday deadline, source says, CNBC](#)

3

МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							Товч тайлбар
	Үнэ (\$) 2021/09/20	Өөрчлөлт					
		өдрийн	7 хоногийн	сарын	оны эхнээс	жилийн	
Зэсийн үнэ	9,050	-2.8	-5.2%	0.3%	2.9%	29.7%	БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн хоёр дахь том корпораци Evergrande хөрвөх чадварын эрсдэлд орж болзошгүй нөлөөгөөр үл хөдлөх хөрөнгийн салбарт үүссэн шок нь зэсийн үнэ өдрийн 2.8 хувиар буурахад нөлөөлөв.
Төмрийн хүдрийн үнэ	99.04	-4.3	-24.4%	-36%	-36.5%	-16.1%	Төмрийн хүдрийн үнэ 5-р сард өмнөх оноос 60 хувийн огцом өсөлтийг үзүүлээд байв. Гэвч гангийн үйлдвэрлэлийн хоригоос шалтгаалан эрэлт болон үнэ буурсны зэрэгцээ Evergrande-ийн санхүүгийн хүндрэл нь түүхий эдийн үнэ



							буурахад нөлөөлж, төмрийн хүдрийн үнэ 9-р сарын 20-нд 99 ам.доллар хүртэл буурлаа.
Алтны үнэ	1,764	0.6%	1.6%	-1.3%	2.1%	-8.3%	БНХАУ-ын Evergrande-ийн санхүүгийн хүндрэлээс шалтгаалан алтны ханш өмнөх 7 хоногоос бага зэрэг өслөө. ХНБ-аас зээлийн өсөлтийг дэмжих, хүүг тогтвортой барих зорилгоор 2020 оны 3-р сараас эхлэн 120 тэрбум ам.долларын үнэт цаасыг худалдан авч байна.
Газрын тосны үнэ (Брент)	73.92	-1.9%	1.2%	8.3%	18.9%	77.1%	АНУ-д болсон хар шуурганы улмаас Royal Dutch Shell, U.S. Gulf of Mexico зэрэг газрын тос боловсруулагч аж ахуй нэгжүүдийн үйлдвэрлэл доголдож, ирэх оны эхний улирал хүртэл газрын тосны нийлүүлэлт багасах төлөвтэй болов. ОПЕК+ нэгдлийн хэлэлцээрийн дараагаас гишүүн улсууд нийлүүлэлтээ танах бодлогоо үргэлжлүүлэхээр байгаа тул өвлийн улиралд газрын тосны нийлүүлэлт эрэлтээ бүрэн хангахааргүй байна.